



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 28. едөр

Дугаар A/95.

Улаанбаатар хот

Г
Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан ЭБ Ану ХХК-ийн "ЭБ" зочид буудлын 15/083, Дөлгөөн Нуур ХХК-ийн "Дөлгөөн Нуур" зочид буудлын 13/78, Дизайнер Клуб ХХК-ийн "Спрингс" зочид буудлын 13/155, Бумбат Хайрхан Нутаг ХХК-ийн "Даймонд" дэн буудлын 14/39, Дунд Номгон ХХК-ийн "ДН" дэн буудлын 14/67, Улаанцарам ХХК-ийн "Эм Жи" дэн буудлын 13/39 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БАТСҮХ

УОЛ0453

E:\NAJG\Alban blanknii helvlelt\Tushaal\A\16.10.28 A95.docx

1150500259

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 10 сарын 28 өдрийн
A/95 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2016.10.28

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Дизайнер Клуб ХХК	Спрингс	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 2А
2	Дөлгөөн Нуур ХХК	Дөлгөөн Нуур	Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, Их тойруу 38
3	ЭБ Ану ХХК	ЭБ	Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Консулын 13

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 10 сарын 28 өдрийн
A/95 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.10.28

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Улаанцарам ХХК	Эм Жи	Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа хороолол 64-01
2	Дунд Номгон ХХК	ДН	Баянзүрх дүүрэг, 2-р хороо, Их Дарь эхийн 1/5в
3	Бумбат Хайрхан Нутаг ХХК	Даймонд	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Ус сувгийн 30

-ооОо-